

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ
ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧИЙН ХАМТАРСАН ТУШААЛ,
ЗАХИРАМЖ

1996 оны 08 дугаар
сарын 15 ны өдөр.

Дугаар А/176, А-186.

Улаанбаатар хот

Нийслэл дахь эрүүл мэндийн
зарим байгууллагуудын зохион
байгуулалтыг өөрчлөх тухай.

Нийслэл дэх хүүхдийн зарим сувиллуудын барилгын хучин чадлыг
бүрэн ашиглах, үйлчилгээний шат дэмжлэг, давхардлыг арилгах,
вахиргаа, аж ахуйн зардлыг багасгах, Түргэн тусламжийн төвийн
авто баазыг бие даалгах төсвийг хөнгөлөх зорилгоор ШИЙЛВЭРЛЭХ НЬ:

1. Элэг, цэсний архаг өвчтэй хүүхдийн сувилал, хараа, сонс-
голын согогтой хүүхдийн эмчилгээ, сургалтын төв, тулгуур эрхтний
согогтой хүүхдийн сувиллуудыг хүүхдийн клиник сувилалд нэгтгэн
"Хүүхдийн клиник сувилал" болгон хүүхдийн клиник сувиллын одоо-
гийн байранд энэ жил 11 улиралд багтаан шилжүүлэн байрлуулахыг
Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газар (Г.Буян-
Өлзий) -т зөвшөөрсүгэй.

2. Нийслэлийн Түргэн тусламжийн төвийн авто баазыг 104761550
төгрөгийн үндсэн хөрөнгө, 17110264 төгрөгийн эргэлтийн хөрөнгө-
тэйгээр улсын үйлдвэрийн газар болгон бие даалган ажиллуулсугай.

3. Элэг, цэсний архаг өвчтэй хүүхдийн сувиллын барилга, бай-
гууламжийг Монгол Улсын хамгааллын тусламжтай "Вихин
Нүүдний эмчилгээ" -н эрхтний төв, сургалтын төв болгон, тулгуур
эрхтний согогтой хүүхдийн сувиллын барилга, байгууламжийг Эрүүл
мэндийн X төвд балансаас балансад шилжүүлэн ашиглуулахыг Нийслэ-
лийн Засаг даргын дэргэдэх Өмчийн газар (Н.Найман), Эрүүл мэндийн
газар (Г.Буян-Өлзий) -т даалгасугай.

4. Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газар
(Г.Буян-Өлзий) -т даалгах нь:

а) Хүүхдийн зарим сувиллуудыг нэгтгэж байгаатай холбогдуулан
элэг, цэсний архаг өвчтэй хүүхдийн сувилал, хараа, сонсголын согог-
той хүүхдийн эмчилгээ, сургалтын төв, тулгуур эрхтний согогтой
хүүхдийн сувиллуудаас эрөн тосгоор нөлөөлөгдөх хүмүүсийг нийслэ-
лийн эрүүл мэндийн байгууллагуудад эхлүүлэн ажиллуулах, Монгол
Улсын Хөдөлмөрийн үндэсний дагуу дүүргүүдийн хөдөлмөр зохицуулах
анхдагч шилжүүлэх.

б) Элэг, цэсний архаг өвчтэй хүүхдийн сувилал, тулгуур
эрхтний согогтой хүүхдийн сувиллуудын барилга, байгууламжаас
бусаад эд, хөрөнгийг Хүүхдийн клиник сувилалд балансаас балансад
шилжүүлэн ажиллуулах.

Түргэн тусламжийн авто бааз, хүүхдийн клиник сувиллын дуомийг шинэчлэн баталж, мөрдүүлэх, авто баазын дарга, клиник сувиллын ерөнхий эмчийг нь шинээр томилон ажиллуулах.

4. Зохион байгуулалтын энэ арга хэмжээтэй холбогдуулан элэг цөсний архаг өвчтэй хүүхдийн сувилал, хараа, сонсголын согогтой хүүхдийн эмчилгээ, сургалтын төв, тулгуур эрхтний согогтой хүүхдийн сувилал, хүүхдийн клиник сувиллуудын орон тоо, төсөвт зохицуулалт хийж өгөхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Сан-хүүгийн хэлтэс (Г.Б. 100) -д холбогдох.

5. Энэ тушаал, захирамж гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайд, Улаанбаатар хотын Ардын Хурлын Гүйцэтгэх захиргааны даргын 1992 оны А/126/212 тоот шийдвэрийн I заалт, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 1994 оны I73 тоот захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН
ХАМГААЛДЫН САМД

П.ЗОРИГ

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД
УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧ
Ц.БААСАНЖАВ

